



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/5/СТА-ТТЗ

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	7
2.8.2 Авлага .....	7
2.8.3 Бараа материал .....	7
2.8.7 Үндсэн хөрөнгө .....	8
2.8.8 Өр төлбөр.....	8
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	9
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
3. Менежментийн захидал .....	13
3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.....	13
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	23
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	25

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

## 1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.03.24 № 1360

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.ОТГОНБАЯР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020288

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Хүрээмарал сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Отгонбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-т заасны дагуу Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 13-аас 2020 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэв.

Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 66 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### 2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хүрээмарал сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Хүрээмарал сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Хүрээмарал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр						
№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	2	4	-	2	-
2	ТБӨӨААН	-	-	-	-	-
	Дүн	2	4	-	2	-

#### 2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хүрээмарал сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хүрээмарал сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан"" программ хангамж ашигладаг байна.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### 2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1674,1 сая төгрөгийн 1.0 хувь буюу 16,7 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1934.2 сая төгрөгийн 1.0 хувь буюу 19,3 сая төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

## 2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4, дүгнэлт өгч, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулж санал дүгнэлт өгөөгүй байна.

Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 110,9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад залрууллаа.

### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд ЕБС-ын орлогын ангиллыг 683,0 мянган төгрөгөөр, цалингийн зардлыг 110,2 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй нэгтгэсэн;

### Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулга хийгдээгүй байна.

### Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

ТТЗ-чийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар акт тогтоогоогүй, албан шаардлага өгөөгүй. Харин харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар нийт 70.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

### Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 2.9 сая залруулга хийгдсэн байна. Үүнд:

Сая төгрөгөөр

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдааны дүн		Үүнээс: Залруулсан алдааны дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.Ерөнхий боловсролын сургууль	1	1.7	1	1.7
2.ЭМТ	1	1,2	1	1,2
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,9</b>	<b>2</b>	<b>2,9</b>

### Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчил

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд залруулагдаагүй дараах 67,2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. /зөрчлийн нэгтгэлийг хавсралтаар харуулсан болно/ Үүнд:

Сая төгрөгөөр

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1.Сумын ЗДТГ	8	20,0	2	1,0	1	0,7	5	18,3
2.ЭМТ	4	3,2					4	3,2
3.СХС	1	15,5	1	15,5				
4. ЕБС	3	21,2	2	10,5			1	10,7

5.Цэцэрлэг	2	5,7	1	4,4			1	1,3
6.ИТХ	2	0,02					2	0,02
7.Соёл	2	0					2	0
8. ОНХС	1	1,6	1	1,6				
<b>ДҮН</b>	<b>23</b>	<b>67,2</b>	<b>7</b>	<b>33,0</b>	<b>1</b>	<b>0,7</b>	<b>15</b>	<b>33,5</b>

## 2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 209.7 сая, эцсийн үлдэгдэл 251.3 сая төгрөг болж, 41.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө	78.5	149.6	71.1	100.0
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>78.5</b>	<b>149.6</b>	<b>71.1</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 149,6 сая төгрөгөөс төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд 82.4 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 32.5 сая, Сум хөгжүүлэх сангийн дансанд 34.7 сая төгрөг байршиж байна.

Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 82.4 сая төгрөгийн үлдэгдэл байгаа нь орон нутгийн давсан орлогоос зарцуулагдаагүй 68,8 сая, төсөвт байгууллагуудын харилцах дансны төвлөрүүлсэн үлдэгдэл 8,1 сая, урьд оны зарцуулаагүй үлдэгдэл 6,7 сая төгрөг байна.

### 2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 201,9 сая, эцсийн үлдэгдэл 240,3 сая төгрөг болж, 38,4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	0.2	0.2
Байгууллагаас авах авлага	83,8	83,2	-0,6
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	-	-	-
Бусад авлага	-	-	-
Зээлийн авлага	118,1	156,9	38,8
<b>Дүн</b>	<b>201,9</b>	<b>240,3</b>	<b>-6.1</b>

Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл нь дараах байдалтай байна. Үүнд:

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл 157,0 сая, ОНХС-аас 78,2 сая, төсөвт байгууллагын байгууллагаас авах авлага 5,0 сая төгрөг эзэлж байна.

### 2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 206,7 сая, эцсийн үлдэгдэл 182,3 сая төгрөг болж, 24,4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	14.1	11.4	-2.7
БНА-2020/5/СТА-ТТЗ			7

Эм боох материал	0.0	0.0	0.0
Дуусаагүй үйлдвэрлэл	0.0	0.0	0.0
Бэлэн бүтээгдэхүүн	0.0	0.0	0.0
Бичиг хэргийн материал	2.9	2.8	-0.1
Аж ахуйн материал	34.7	44.6	9.9
Сэлбэг хэрэгсэл	0.0	0.0	0.0
Түлш, шатах тослох материал	10.4	0.2	-10.1
Хүнсний материал	2.2	2.4	0.2
Бусад хангамжийн материал	129.3	113.3	-16.0
Биологийн хөрөнгө	0.5	0.5	0.0
Мал амьтад	12.7	7.1	-5.6
<b>Дүн</b>	<b>206.7</b>	<b>182.3</b>	<b>-24.4</b>

Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3765,0 сая, эцсийн үлдэгдэл 3823,7 сая төгрөг болж, 58,7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	2,639.0	2,681.2	42.1
Тээврийн хэрэгсэл	180.1	175.7	(4.4)
Машин тоног төхөөрөмж	527.7	496.1	(31.6)
Тавилга эд хогшил	272.8	308.4	35.7
Түүх соёлын дурсгалт зүйл	0.2	0.2	-
Номын фонд	31.9	34.8	2.9
Бусад үндсэн хөрөнгө	46.7	46.7	-
Дуусаагүй барилга, байгууламж	7.4	21.4	14.0
Программ хангамж	3.1	3.1	-
Бусад биет бус хөрөнгө	56.1	56.1	-
<b>Дүн</b>	<b>3,765.0</b>	<b>3,823.7</b>	<b>58.7</b>

Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 69,9 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 121,1 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 11,7 сая төгрөгөөр нэмэгдэж, акталсан устгасан 144,0 сая төгрөгөөр хасагдсан байна.

### 2.8.8 Өр төлбөр

Тайлант оны эхэнд өглөггүй байсан бөгөөд эцсийн үлдэгдэл 7,4 сая төгрөг болж өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	-	7.4	7.4	1.35
Ажилчидтай холбогдсон өглөг	-	0.1	0.1	0
Байгууллагад төлөх өглөг	-	6.6	6.6	89.2
Хувь хүмүүст төлөх өглөг	-	0.7	0.7	9.45
Урт хугацаат өр төлбөр дүн	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>-</b>	<b>7.4</b>	<b>7.4</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 7,2 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг, 0,1 сая төгрөгийн ажилчидтай холбоотой өглөг байгаа ба 6,0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн тайланд өглөгөөр тусгасан голлох нөлөөг үзүүлж байна.

### Хүснэгт 6. Өглөгийн үлдэгдэл байгууллагаар

сая.төг

Байгууллагын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Ажиллагсадтай холбоотой	Байгууллагад өгөх	Зөрүү /өссөн+/, Буурсан-/	Дүнд эзлэх хувь
Сургууль	-	-	-	-	-	0.0
Цэцэрлэг	-	0.2	-	0.2	0.2	2.0
Эрүүл мэндийн төв	-	-	-	-	-	0.0
Соёлын төв	-	0.1	0.1	-	0.1	1.9
ИТХ	-	1.1	-	1.1	1.1	14.3
ЗДТГ	-	-	-	-	-	0.0
ОНХС	-	6.0	-	6.0	6.0	81.1
СХС	-	-	-	-	-	0.0
<b>Нийт дүн</b>	-	<b>7.4</b>	<b>0.1</b>	<b>7.2</b>	<b>7.4</b>	<b>100.0</b>

## 2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3123,4 сая, эцсийн үлдэгдэл 3123,4 сая төгрөг болж, 66,3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Өмч /төрийн/	1,578.6	1,578.6	-	49.5
Хуримтлагдсан үр дүн	346.8	456.5	109.7	14.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,198.0	1,154.6	(43.4)	36.2
<b>Дүн</b>	<b>3123,4</b>	<b>3189,7</b>	<b>66,3</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс өөрчлөлт нь тайлант оны хуримтлагдсан үр дүн 109,7 сая төгрөгөөр нэмэгдэж, Соёлын төвийн 56,0 сая, ИТХ-ын 3,5 төгрөгийн дахин үнэлгээтэй хөрөнгө акталсантай холбоотой хөрөнгө дахин үнэлгээний нөөц данс 43,4 сая төгрөгөөр буурсан байна.

## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2019 оны төсөв батлах тухай 14/03 дугаар тогтоолд зааснаар Хүрээмарал сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 6.0 сая, аймгийн төсөвт 79.1 сая нийт 85.1 сая төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 84.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 99,3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1.Улсын төсөвт төвлөрүүлэх орлого</b>	<b>6.0</b>	<b>4.4</b>	<b>(1.6)</b>	<b>100.0</b>
1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	2.0	2.4	0.4	54.5
1.2.Нэмэгдсэн өртгийн албан татвар	3.3	1.2	(2.1)	27.3
1.3.Агаарын бохирдлын төлбөр	0.7	0.8	0.1	18.2
<b>2.Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого</b>	<b>79.1</b>	<b>80.1</b>	<b>1.0</b>	<b>100.0</b>
2.1.Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	70.0	69.9	(0.1)	87.3
2.2.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.8	1.0	0.2	1.2
2.3.Газрын төлбөр	1.8	1.0	(0.8)	1.2
2.4.Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	6.5	8.2	1.7	10.2
<b>Нийт дүн</b>	<b>85.1</b>	<b>84.5</b>	<b>(0.6)</b>	<b>99,3</b>

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 1.6 сая төгрөгөөр тасарсан нь нэмэгдсэн өртгийн татвар төлөгчдийн тоо өмнөх оноос буурснаас тус татварын тасарсантай холбоотой байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөнөөс 1,0 сая төгрөгөөр давж биелсэн нь АБӨЯХАТ нь 1.7 сая төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 9/04 тоот тогтоолоор сумд төвлөрөх татварын болон татварын бус орлогыг 36,6 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 101,7 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 278 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Сумын орон нутгийн орлого /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1.Татварын орлого</b>	<b>34.1</b>	<b>91.4</b>	<b>57.3</b>	<b>268.0</b>
ИОТХ	8.0	8.8	0.8	110.0
Хадгаламжийн хүүгийн орлого	20.0	27.6	7.6	138.0
Бууны татвар	1.5	1.6	0.1	106.7
Ан агнуур нөөц ашигласны	-	51.2	51.2	-
Улсын тэмдэгтийн хураамж	1.5	1.1	(0.4)	73.3
Ус рашаан	-	0.2	0.2	-
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	2.5	-	(2.5)	-
ТТАМАТөлбөр	0.3	0.6	0.3	200.0
Нохойны татвар	0.3	0.3	-	100.0
<b>2.Татварын бус орлого</b>	<b>2.5</b>	<b>10.4</b>	<b>7.9</b>	<b>416.0</b>
2.1.Хүү торгуулийн орлого	2.5	10.4	7.9	416.0
<b>Нийт дүн</b>	<b>36.6</b>	<b>101.8</b>	<b>65.2</b>	<b>278.1</b>

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 1895,7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1770.3 сая төгрөгийг урсгал зардалд, 124.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 528,1 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 1048,1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 17,7 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 90,7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 38.0 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 34,8 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 131,8 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилт, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтийг бүрэн авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 47.9 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 19,4 сая төгрөгөөр тасарсан нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн төлөлтийн дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлого 17,7 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 17,1 сая төгрөгөөр тасарсан нь Орон нутгийн хөгжлийн сангийн туслах үйл ажиллагааны орлогоор төвлөрөхөөр төлөвлөгдсөн орлого дутуу төвлөсөнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1777,0 сая төгрөг буюу 93,8 хувьтай байгаа нь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6.5 сая хэмнэгдсэний 6,3 сая төгрөг нь Соёлын төв, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6,8 сая төгрөг хэмнэгдсэний 5,9 сая төгрөг нь Цэцэрлэг, БГАУ-ний төлбөр хураамж 53,7 сая төгрөгөөр хэмнэгдсэний 51,3 сая төгрөг нь СХС-д олгосон зээлийн төлбөр бүрэн төвлөрүүлээгүйгээс зээл дутуу олгосноос, тус тус хэмнэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 10. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар

сая.төг

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Засаг даргын Тамгын газар	331.6	329.0	2.6	99.2
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	72.5	70.8	1.7	97.7
Ерөнхий боловсролын сургууль	554.3	552.4	1.9	99.7
Цэцэрлэг	226.9	222.3	4.6	98.0
Эрүүл мэндийн төв	371.9	371.4	0.5	99.9
Соёлын төв	78.5	70.7	7.8	90.1
Орон нутгийн хөгжлийн сан	124.9	77.1	47.8	61.7
Сум хөгжүүлэх сан	134.7	83.4	51.3	61.9
<b>Нийт дүн</b>	<b>1,895.3</b>	<b>1,777.1</b>	<b>118.2</b>	<b>93.8</b>

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 41.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт бүрдүүлж бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 30,2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 11,7 сая төгрөгийг аймгийн төрийн санд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 11. Нэмэлт төсвийн судалгаа

Байгууллагын нэр	Санхүүжилт	Зарцуулалт	Төвлөрүүлсэн	
			Аймаг	Сум
Засаг даргын Тамгын газар	37.7	26.0	-	11.7
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2.3	2.3	-	-
Соёлын төв	1.1	1.1	-	-
Эрүүл мэндийн төв	0.1	0.1	-	-
Сургууль	0.7	0.7	-	-
<b>Нийт дүн</b>	<b>41.9</b>	<b>30.2</b>	<b>0</b>	<b>11.7</b>

**2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**  
Дараагийн аудитаар анхаарч үзэх асуудал байхгүй

**2.11. Шилэн дансны мэдээлэл**

Хүрээмарал сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 129 мэдээллийг хугацаанд нь, 25 мэдээлэлд дахин завсар хийснээс хугацаа хоцроосон байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	10	1	0
2	Хагас жил	3	3	3	0	0
3	Улирал бүр	2	8	8	0	0
4	Сар бүр	5	60	55	5	0
5	Тухай бүр	6	72	53	19	0
6	Нийт	27	154	129	25	0

**2.12. Өмнөх зөвлөмжийн ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага зөвлөмж өгөөгүй, санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

**2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хүрээмарал сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр

хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хүрээмарал сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт: Байгууллагуудын санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд аудитлагдсан тайлангаас зөрүүтэй шивсэн байхад шалгаж хүлээн аваагүй баталгаажуулсны улмаас үр дүн мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 683,0 мянга, зардлыг 110283,0 мянган төгрөгийг ангилал хооронд зөрүүтэй илэрхийлсэн

3.1.2 Эрсдэл: Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан үнэн зөв нэгтгэгдэхгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн шууд захирагчийн тайланг Сангийн яамны “Э-Тайлан”-нд шивэхдээ Төрийн сангийн хэлбэлзэл, аудитлагдсан санхүүгийн тайлантай тулгаж, үнэн зөв шивж буй эсэхэд хяналт тавьж ажиллах.

3.2.1. Харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар нийт 70.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

3.2.2 Эрсдэл: Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан үнэн зөв нэгтгэгдэхгүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж: ТШЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтаа сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>491,013,325.26</b>	<b>576,111,848.97</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	78,521,067.94	149,571,378.15
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	78,521,067.94	149,571,378.15
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	78,521,067.94	149,571,378.15
31211	Төрийн сангийн харилцах	78,521,067.94	149,571,378.15
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	201,875,029.22	240,329,119.22
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		168,993.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	83,749,649.22	83,189,009.22
3351	Байгууллагаас авах авлага	3,066,881.22	4,983,241.22
3352	Хувь хүмүүсээс авах авлага	80,682,768.00	78,205,768.00
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	118,125,380.00	156,971,117.00
<b>3361</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	118,125,380.00	156,971,117.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	118,125,380.00	156,971,117.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	206,730,228.10	182,324,351.60
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	14,121,498.00	11,430,935.00
35110	Тусгай зориулалттай материал	14,121,498.00	11,430,935.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	179,932,730.10	163,797,416.60
35410	Бичиг хэргийн материал	2,868,975.00	2,803,455.00
35420	Аж ахуйн материал	34,737,685.00	44,599,471.00
35440	Түлш, шатах тослох материал	10,385,400.00	237,100.00
35450	Барилгын засварын материал	459,000.00	459,000.00
35460	Хүнсний материал	2,151,210.40	2,398,790.40
35470	Бусад хангамжийн материал	129,330,459.70	113,299,600.20
35600	Мал амьтад	12,676,000.00	7,096,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	3,887,000.00	3,887,000.00
36100	Барааны нөөц	3,887,000.00	3,887,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,632,364,912.53</b>	<b>2,620,941,367.65</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,632,364,912.53	2,620,941,367.65
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,576,260,912.53	2,564,837,367.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,639,026,702.00	2,681,151,402.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-480,733,607.94	-549,918,700.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	180,134,800.00	175,724,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-75,480,661.13	-88,308,127.73
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	527,709,897.91	496,134,399.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	-390,001,626.70	-363,920,896.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	272,762,071.19	308,423,298.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-166,724,502.59	-176,203,893.84
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	245,888.00	245,888.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	46,741,537.12	46,741,537.12
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,724,691.51	-21,398,845.23
39216	Дуусаагүй барилга, байгууламж	7,400,000.00	21,400,000.00
39217	Ном	31,905,106.18	34,766,506.18
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	56,104,000.00	56,104,000.00
39301	Програм хангамж	3,092,600.00	3,092,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,092,600.00	-3,092,600.00
39303	Бусад биет бус хөрөнгө	56,104,000.00	56,104,000.00

3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,123,378,237.79</b>	<b>3,197,053,216.62</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>7,350,602.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	7,350,602.00
413	<b>Өглөг</b>	0.00	7,350,602.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		142,590.00
4136	<b>Бусад өглөг</b>	0.00	7,208,012.00
41361	Байгууллагад төлөх өглөг		6,550,012.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		658,000.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,123,378,237.79</b>	<b>3,189,702,614.62</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,123,378,237.79	3,189,702,614.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,578,564,041.25	1,578,564,041.25
51101	Өмч: - төрийн	1,578,564,041.25	1,578,564,041.25
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	346,807,724.21	456,525,407.54
51210	Өмнөх үеийн үр дүн	271,017,827.55	390,201,030.71
51220	Тайлант үеийн үр дүн	75,789,896.66	66,324,376.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,198,006,472.33	1,154,613,165.83
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,123,378,237.79</b>	<b>3,197,053,216.62</b>

